



ГАРЧИГ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

596.	Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай	Дугаар 170	2265
597.	Үндэсний хороо байгуулах тухай	Дугаар 171	2265

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2012 оны 09 дүгээр сарын 18-ны өдөр

Дугаар 170

Улаанбаатар хот

Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Монгол Улсаас Унгар Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Омбоосүрэнгийн Эрдэнэчимэгийг эгүүлэн татаж, Монгол Улсаас Унгар Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Төгсжаргалын Гандийг томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**ЦАХИАГИЙН
ЭЛБЭГДОРЖ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2012 оны 09 дүгээр сарын 18-ны өдөр

Дугаар 171

Улаанбаатар хот

Үндэсний хороо байгуулах тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг, Агаарын тухай Монгол Улсын хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1, 5.2 дахь хэсэгт заасныг үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

1. Агаарын бохирдлыг бууруулах Үндэсний хорооны бүрэлдэхүүнийг 1 дүгээр хавсралтаар, Үндэсний хорооны ажиллах журмыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.



2. Энэхүү журмыг баталсантай холбогдуулан Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2011 оны 3 дугаар сарын 3-ны өдрийн 43 дугаар зарлигийг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**ЦАХИАГИЙН
ЭЛБЭГДОРЖ**

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2012 оны
09 дугаар сарын 18 өдрийн 171 дугаар
зарлигийн 1 дүгээр хавсралт

**АГААРЫН БОХИРДЛЫГ БУУРУУЛАХ
ҮНДЭСНИЙ ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН**

Дарга

-Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга

Дэд дарга

-УИХ-ын Агаарын бохирдлыг бууруулах
дэд хорооны дарга;

-Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар
хотын захирагч

Гишүүд:

-Ерөнхийлөгчийн хот, хөдөөгийн бодлогын
зөвлөх;

-Ерөнхийлөгчийн байгаль орчин, амьдрах орчны
бодлогын зөвлөх;

-Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;

-Байгаль орчин, ногоон хөгжлийн яамны Төрийн
нарийн бичгийн дарга;

-Эдийн засгийн хөгжлийн яамны Төрийн нарийн
бичгийн дарга;

-Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн
дарга;

-Барилга, хот байгуулалтын яамны Төрийн
нарийн бичгийн дарга;

-Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн
дарга;

-Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн
дарга;

-Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга;

-Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
дарга;

-Цагдаагийн ерөнхий газрын дарга;



**Нарийн бичгийн
дарга**

- Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга;
- Стандартчилал, хэмжил зүйн газрын дарга;
- Нийслэлийн Засаг даргын үйлдвэрлэл, экологийн асуудал хариуцсан орлогч;
- Монголын Мянганы сорилтын сангийн гүйцэтгэх захирал;
- Монголын Архитекторчдын холбооны ерөнхийлөгч;
- Шинжлэх ухааны академийн ерөнхийлөгч;
- Худалдан авах ажиллагааны газрын дарга;
- Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын албаны дарга.
- Үндэсний хорооны Ажлын албаны дарга

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2012 оны
09 дугаар сарын 18 өдрийн 171 дугаар
зарлигийн 2 дугаар хавсралт

**АГААРЫН БОХИРДЛЫГ БУУРУУЛАХ
ҮНДЭСНИЙ ХОРООНЫ АЖИЛЛАХ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Агаарын тухай Монгол Улсын хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1-д заасан агаарын бохирдлыг бууруулах бодлогын хэрэгжилтийг зохицуулах, үйл ажиллагааны харилцан уялдааг хангахад хяналт тавих үүрэг бүхий Агаарын бохирдлыг бууруулах Үндэсний хороо /цаашид Үндэсний хороо гэх/-ны үйл ажиллагааг зохицуулахад энэхүү журмын зорилго оршино.

1.2. Үндэсний хороо нь үйл ажиллагаандаа Агаарын тухай хууль болон бусад хууль тогтоомж, энэхүү журмыг удирдлага болгон ажиллана.

1.3. Үндэсний хороо ажлаа Улсын Их Хурал, Ерөнхийлөгчийн өмнө хариуцна.

Хоёр. Бүрэлдэхүүн, зохион байгуулалт

2.1. Үндэсний хорооны дарга нь Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга байна.

2.2. Үндэсний хороо нь орон тооны нарийн бичгийн даргатай байх бөгөөд нарийн бичгийн дарга нь хорооны Ажлын албаны дарга байна.



2.3. Үндэсний хорооны бүрэлдэхүүнд УИХ-ын холбогдох дэд хороо, яам, агентлаг, мэргэжлийн байгууллагын удирдах албан тушаалтан орох бөгөөд бүрэлдэхүүнийг Ерөнхийлөгч батална.

2.4. Үндэсний хороо нь Ажлын албатай байна.

2.5. Ажлын албыг Үндэсний хорооны нарийн бичгийн дарга (цаашид Ажлын албаны дарга гэх) удирдана. Ажлын албаны дарга нь ажлаа Үндэсний хорооны даргын өмнө хариуцаж, жилд 2 удаа үйл ажиллагаагаа Үндэсний хороонд тайлагнана.

2.6. Ажлын алба нь албаны дарга, ажилтнуудаас бүрдсэн 9 хүртэл орон тоотой байна.

2.7. Үндэсний хороо, Ажлын албаны үйл ажиллагааны зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ.

2.8. Үндэсний хороо, Ажлын алба нь холбогдох журмын дагуу үйлдсэн тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэж банкинд данстай байна.

2.9. Үндэсний хороо, Ажлын алба нь цахим мэдээллийн сантай байна.

2.10. Үндэсний хороо нь нийслэлийн дүүрэг бүрт тухайн дүүргийн Засаг даргаар ахлуулсан салбар хороотой байх бөгөөд салбар хороодын үйл ажиллагааг шууд удирдлагаар хангаж ажиллана. Салбар хороодын бүрэлдэхүүнийг Нийслэлийн Засаг дарга батална.

Гурав. Үндэсний хорооны бүрэн эрх

3.1. Үндэсний хороо дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

3.1.1. Агаарын бохирдлыг бууруулах талаарх салбар дундын бодлогын хэрэгжилтийг хангах үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, хэрэгжилтэнд хяналт тавих;

3.1.2. Агаарын бохирдлыг бууруулахад чиглэсэн үйл ажиллагааны асуудлаар холбогдох байгууллага албан тушаалтанд үүрэг даалгавар өгч, биелэлтэнд хяналт тавих;

3.1.3. Агаарын бохирдлыг бууруулах талаар хийж байгаа ажил, ажлын төлөвлөгөөний биелэлтийн тухай холбогдох албан тушаалтны сонсгол, тайланг авч хэлэлцэх, мэдээ тайлан гаргуулан авах;

3.1.4. Агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээний жилийн төлөвлөгөөг нэгтгэн боловсруулах, хэрэгжилтийг зохион байгуулж биелэлтэнд хяналт тавих;



3.1.5. Агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөнд шаардагдах хөрөнгийн тооцоо, эх үүсвэрийн асуудлыг уялдуулан зохицуулж санхүүжилтэнд хяналт тавих;

3.1.6. “Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсийн дэглэмийн хэрэгжилтэнд хяналт тавих, шаардлагатай арга хэмжээг авах;

3.1.7. Агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр ажиллаж байгаа дотоод, гадаадын төсөл хөтөлбөр, сангийн үйл ажиллагааны нэгдсэн мэдээлэл, судалгааны санг бүрдүүлж харилцан уялдааг хангаж зохицуулах;

3.1.8. Агаарын чанарын мэргэжлийн албадын үйл ажиллагааг удирдан чиглүүлж нэгдсэн удирдлагаар хангах, шаардлагатай судалгаа мэдээллийг гаргуулан авах;

3.1.9. Агаарын бохирдлыг бууруулахад иргэдийн үүрэг оролцоог нэмэгдүүлэх, идэвхи санаачлагыг дэмжиж урамшуулах, агаарын төлөв байдлын тухай нийтэд мэдээлдэг тогтолцоог бий болгох ажлыг зохион байгуулах;

3.1.10. Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулахад үр дүнгээ өгч буй арга хэмжээг бусад аймгын төв, хот суурин газарт хэрэгжүүлэх талаарх саналаа холбогдох төрийн байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх, арга зүйн туслалцаа үзүүлэх, хамтран зохион байгуулах;

3.1.11. Нийслэлийн болон бусад хот суурин газрын агаарын бохирдлыг бууруулахад шаардлагатай арга хэмжээний талаар саналаа Засгийн газарт тавьж шийдвэрлүүлэх;

3.1.12. Агаарын бохирдлыг бууруулах тухай хууль тогтоомжинд заасан бүрэн эрх, хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй, эсхүл хангалтгүй биелүүлсэн аобан тушаалтанд хариуцлага хүлээлгэх үндэслэл боловсруулах, санал гаргах;

3.1.13. Үндэсний хороо нь орон нутгийн өөрөө удирдах байгууллагын зүгээс агаарын чанарыг сайжруулах чиглэлээр боловсруулсан хөтөлбөр төлөвлөгөө, хэрэгжүүлж буй ажлуудад дэмжлэг үзүүлэн, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, хяналт тавьж ажиллах;

3.1.14. Монгол Улсын Засгийн газрын тусгай сан “Цэвэр агаарын сан”-гийн тухайн жилд хэрэгжүүлэх үйл ажиллагаанд санал боловсруулан оруулах;



Дөрөв. Үндэсний хорооны дарга, гишүүдийн бүрэн эрх

4.1. Үндэсний хорооны дарга дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

4.1.1. Үндэсний хорооны хурлаар хэлэлцэх асуудлыг тодорхойлж, хурлыг товлох;

4.1.2. Үндэсний хорооны хурлын дэгийг батлах;

4.1.3. Бүрэн эрхийнхээ хүрээнд хуульд нийцүүлэн захирамж гаргах;

4.1.4. Үндэсний хороог төлөөлөх;

4.1.5. Тодорхой асуудлаар Үндэсний хорооны Ажлын хэсэг, удирдлагын баг байгуулж, ажиллуулах;

4.1.6. Үндэсний хорооны Ажлын албаны дарга, ажилтнуудыг томилох, чөлөөлөх;

4.1.7. Хууль тогтоомжинд заасан бусад бүрэн эрх;

4.2. Үндэсний хорооны гишүүн дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

4.2.1. Агаарын бохирдлыг бууруулах талаар авах арга шаардлагатай арга хэмжээний тухай санал боловсруулан Үндэсний хорооны хурлаар хэлэлцүүлэх;

4.2.2. Үндэсний хорооны хурал дээр үг хэлэх, таслах эрхтэй оролцох;

4.2.3. Үндэсний хорооны шийдвэрийн биелэлтийг эрхэлсэн ажлын хүрээндээ зохион байгуулах;

4.2.4. Үндэсний хорооны Ажлын хэсэг, удирдлагын баг байгуулах санал тавих;

4.2.5. Ажлын алба, Үндэсний хорооны Ажлын хэсэгт үүрэг, чиглэл өгөх;

4.2.6. Хууль тогтоомжинд заасан бусад бүрэн эрх;

Тав. Үндэсний хорооны ажиллах журам

5.1. Үндэсний хорооны үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хурал байна. Хурлыг Үндэсний хорооны дарга удирдах ба түүний эзгүйд Үндэсний хорооны Дэд дарга даргална.

5.2. Үндэсний хороо нь сар тутам хуралдах бөгөөд шаардлагатай үед Үндэсний хорооны дарга ээлжит бус хурал зарлан хуралдуулж болно.

5.3. Салбарын дэд сайд, яамдын Төрийн нарийн бичгийн дарга, агентлаг, мэргэжлийн байгууллагын дарга, Нийслэлийн Засаг даргын



орлогч нар Үндэсний хорооны хуралд илтгэгч байх бөгөөд зохих илтгэл, танилцуулга, санал, шийдвэрийн төслийг боловсруулан Ажлын албанд ирүүлнэ.

5.4. Үндэсний хорооны гишүүд Үндэсний хорооны хурлаар хэлэлцүүлэх асуудлын талаарх саналаа тухай бүр Ажлын албанд ирүүлнэ.

5.5. Үндэсний хорооны хурлаар хэлэлцүүлэх асуудлын төлөвлөгөөг улирал, сараар төлөвлөн Үндэсний хороо батална. Төлөвлөгөөнд тодотгол хийж болно.

5.6. Үндэсний хороог хуралдуулах бэлтгэл ажлыг Ажлын албаны дарга хариуцан зохион байгуулна.

5.7. Үндэсний хорооны хурлаар хэлэлцэх асуудлын материал нь дараахь бүрдэлтэй байна. Үүнд:

5.7.1.Хэлэлцэх асуудлын танилцуулга,

5.7.2.Түүнд холбогдох тооцоо, судалгаа, санал дүгнэлт, хавсралтууд,

5.7.3.Хурлаас гарах шийдвэрийн төсөл.

5.8. Үндэсний хорооны хурлаар хэлэлцэх материалыг Ажлын албаны дарга нягтлан үзээд, хурал болох өдрөөс ажлын 5-аас доошгүй хоногийн өмнө Үндэсний хорооны даргад танилцуулж хурлаар хэлэлцүүлэх зөвшөөрөл авч, хурлаар хэлэлцэх асуудлын дараалалд оруулна. Хурлаар хэлэлцэх асуудлын дараалалд орсон материалыг хурал болохоос ажлын 2-оос доошгүй хоногийн өмнө Үндэсний хорооны гишүүдэд хүргүүлнэ.

5.9. Шаардлагатай гэж үзвэл Үндэсний хорооны хуралд хэлэлцэж байгаа асуудалтай холбоотой иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын төлөөллийг оролцуулан мэдээллийг сонсоно.

5.10. Үндэсний хороо нь үйл ажиллагаагаа жилээр төлөвлөж, тайлангаа хагас, бүтэн жилээр хэлэлцэж, дүгнэнэ. Ажлын явц тайланг улирал бүр Ерөнхийлөгчид илтгэж байх бөгөөд шаардлагатай гэж үзвэл Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн хуралдаанд танилцуулж байна.

5.11. Үндэсний хорооны хурлын чөлөөт цагт Үндэсний хорооны ажлыг Үндэсний хорооны дарга, Ажлын албаны дарга зохион байгуулна.

Зургаа. Үндэсний хорооны хурлын шийдвэр,
түүнийг хэрэгжүүлэх

6.1. Үндэсний хорооны гишүүдийн олонхи оролцсон тохиолдолд



хурлыг хүчинтэйд тооцох бөгөөд асуудлыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонхийн саналаар шийдвэрлэнэ.

6.2. Хүндэтгэх шалтгаанаар хуралд оролцож чадаагүй гишүүдийн саналыг бичгээр авч тооцож болох бөгөөд хүндэтгэх бус шалтгаанаар хуралд оролцоогүй, эсхүл хэлэлцэж буй асуудлыг хүлээн зөвшөөрөхгүй учраас хуралд оролцохоос татгалзсан гишүүдийг эсрэг санал өгснөөр тооцон хурлын шийдвэрийг гаргана.

6.3. Үндэсний хорооны хурлаас гарах шийдвэр нь тогтоол, тэмдэглэл байна.

6.4. Үндэсний хорооны хурлаас гарах шийдвэр нь хууль тогтоомжинд нийцсэн байх бөгөөд заавал биелэгдэх шинжтэй байна.

6.5. Үндэсний хорооны хурлын шийдвэрийг үндэслэн төрийн байгууллага, албан тушаалтан өөрийн чиг үүрэг, бүрэн эрхийнхээ дагуу холбогдох шийдвэр гаргаж зохих журмаар хэрэгжүүлнэ.

6.6. Үндэсний хорооны хурлын явцын дэлгэрэнгүй тэмдэглэлийг албажуулах асуудлыг Ажлын албаны дарга хариуцна.

6.7. Үндэсний хорооны хурлын тэмдэглэлд Ажлын албаны дарга гарын үсэг зурж, Үндэсний хорооны дарга баталгаажуулна.

6.8. Үндэсний хорооны гишүүд нь хурлаас гарсан шийдвэртээ хамтын хариуцлага хүлээнэ.

6.9. Үндэсний хорооны хурлаас гарсан шийдвэрийн биелэлтийг холбогдох байгууллага, албан тушаалтан тогтосон хугацаанд хариу мэдээлэх, тайлагнах үүрэгтэй.

ЗАЛРУУЛГА

"Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2012 оны 36/753/ дугаарт нийтлэгдсэн Аймаг, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2.3 дахь заалтын "энэ хуулийн 22.2-т заасан" гэснийг "энэ хуулийн 22.3-т заасан" гэж залруулан уншина уу.

Хаяг:

"Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн редакци.
Улаанбаатар-12, Төрийн ордон 124 тоот
И-мэйл: turii_medeel@parliament.mn
Утас: 262420, 329612
Хэвлэлийн хуудас: 0.5
Индекс: 14003